



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/260

Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" дахь заалт, 29.2 дахь хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.7 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/84 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа (дарс) үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй "Шимт дээж" ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Баттайван	-(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
Гишүүд:	Б.Бүрэнжаргал	-(Татварын хэлтсийн Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга)
	Н.Буянхишиг	-(Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хүүхдийн асуудал хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн)
	Э.Танхилмаа	-(Мэргэжлийн хяналтын газрын газрын хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)
	Б.Сумъяа-Ичинхорлоо	-(Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй, халдвар, хамгааллын хяналтын улсын байцаагч)

2.

Нарийн бичгийн дарга: П.Мөнхзаяа

-(Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
Үйлдвэрлэл, худалдаа  
үйлчилгээний албаны хүнсний  
үйлдвэрлэл, нийтийн хоол,  
худалдаа хариуцсан  
мэргэжилтэн)

2.Холбогдох хууль, журмын дагуу хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, гарсан дүгнэлт, саналыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Д.Баттайван)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ